

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурлын тэмдэглэл

2021-04-09

Улаанбаатар хот

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2021-04-09-ний 11:00 цагт компанийн сургалтын танхимд болов.

Тооллогын комиссын дарга Г.Однаран хурлын ирцийг мэдээлж, комиссын тогтоол №1-ийг танилцуулав: Хуралд нийт хувьцааны **95,2%**-ийг төлөөлсөн буюу **385482 ширхэг хувьцааг** эзэмшиж буй 11 хувьцаа эзэмшигч оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөр гэж үзэж, ирцийн бүртгэлийн материалыг хурлын тэргүүлэгчдэд хүлээлгэн өгөв.

Хурлын даргаар ТУЗ-ийн 2021-02-10-ны хурлаар томилогдсон Ё.Энхтөр ажиллав.

Ё.Энхтөр: Ирц бүрдсэн тул хурлаа эхэлье. Хурлын хэлэлцэх асуудал, дэгийг танилцуулав. Хурлын хэлэлцэх асуудлууд:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны үр дүн, 2021 оны үндсэн зорилт, үзүүлэлтийн тухай

2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт

3. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны 2021 оны зардлын төсөв батлах тухай

Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу ТУЗ-ийн дарга Ц.Зоригт эхний асуудлыг танилцуулав: Материал урьдчилан хүн бүрт тараагдсан тул товчлон яриу.

“Улаанбаатар хивс” ХК нь 2020 оны хувь нийлүүлэгчдийн хурлаас дэвшүүлсэн зарилтыг хэрэгжүүлэх хүрээнд компанийн хамт олны хүч хөдөлмөрийг зүй зохистой зохион байгуулж ажиллав. 2021 оны 03-03-ны өдрөөр үнэт цаасны 47 компанид 904 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байгаа бөгөөд компанийн зах зээлийн үнэлгээ 9,7 тэрбум төгрөг болсон байна. 52 долоо хоногийн дунджаар нэгж хувьцааны үнэ: 16000-24000 төгрөг байв. 2020 оны ажлын үр дүнгээр нэгж хувьцаанд 600,0 төгрөг буюу нийт 242,9 сая төгрөг хуваарилахаар ТУЗ-өөс шийдвэрлэсэн.

2020 онд ТУЗ 3 удаа хуралдаж, 9 тогтоол гаргав.

2020 онд компанийн хамт олон 39600 м2 хивс үйлдвэрлэж, 39977 м2 хивс борлуулав. Энэ нь өнгөрсөн оныхоос буурсан нь дэлхий дахинд тархсан ковид-19 цар тахлаас шалтгаалсан байна. Харин цэвэр ашиг 317,9 сая төгрөг болсон нь өмнөх оныхоос 19,1 сая төгрөгөөр илүү байна.

Үйлдвэрлэлийн алба, маркетингийн алба, сургалт хүний нөөцийн алба болон санхүү эдийн засгийн албадын хийсэн ажлын тайланг танилцуулав.

2021 онд хүрсэн түвшин, зах зээлийн хандлага, цар тахлын тархалт зэргийг харгалзан үйл ажиллагааны дараахь үндсэн зорилтыг дэвшүүлж байна:

- | | |
|------------------------------|-----------------|
| 1. Үйлдвэрлэлт: | 50000 м2 хивс |
| 2. Борлуулалт: | 4400 сая төгрөг |
| 3. Хөрөнгө оруулалт: | 500 сая төгрөг |
| 4. Цэвэр ашиг: | 405 сая төгрөг |
| 5. Үйлдвэрлэлийн нэгж өртөг: | 72000 төгрөг |

Манай хамт олон компани байгуулагдсаны 50 жилийн ойн жил болох 2021 онд техник, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, гадаад дотоодын борлуулалтын сүлжээгээ нэмэгдүүлэхэд анхаарал тавьж ажиллана.

Ё.Энхтөр: 2 дахь асуудлыг Б.Баясгалан танилцуулна.

Б.Баясгалан: Компани нь “Релаэнс секюритиз аудит” ХХК-аар дүгнэлт гаргуулсан. Компанийн 2020-12-31-ний өдрөөх баланс, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу илэрхийлэгдсэн байна гэж дүгнэсэн. Аудитын дүгнэлтийг хурлын материалд хавсаргаснаар танилцуулав.

Өнгөрсөн жил Аудитаас өгсөн зөвлөмжийн дагуу

1. Үүсээд удсан өр авлагуудыг барагдуулж цэгцлэх
2. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх
3. НББ-ийн бодлогын бичиг баримтыг шинэ программтай уялдуулан шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Ё.Энхтөр: 3-р асуудлыг ярья.

Н.Батцэцэг: Компанийн ТУЗ-ийн 2021 онд зарцуулах зардлын төсвийг 13,5 сая төгрөгөөр тогтоохоор оруулж байна. Ноднингийхоос 1,0 сая төгрөг илүү байгаа нь ТУЗ-ийн нарийн бичгийн дарга гаднаас нэмэгдэж орж ирсэнтэй холбоотой.

Ё.Энхтөр: Одоо асуулт, санал, шүүмжлэлдээ оръё.

Л.Цэвэрнравдан: Засгийн газрын цар тахалд зориулсан хөнгөлөлтөөс компани ямар хөнгөлөлт эдэлсэн бэ?

Б.Баясгалан: 2020-04-р сараас 12-р сар хүртэл НДШ-ийн 78,0 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлсэн. Цахилгаан, дулааны хөнгөлөлт 110,0 гаруй сая төгрөг урьдчилсан тооцоогоор явж байгаа.

Ё.Энхтөр: 2020 онд үндсэндээ үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ бүгдийг борлуулсан байна. 1,9 тэрбум бараа, материалд юу орж байгаа вэ?

Б.Баясгалан: Түүхий эд материал 693,0 сая ₮, дуусаагүй үйлдвэрлэл 150,0 сая ₮, бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 1,064 сая ₮ тус тус байгаа.

Л.Цэвээнравдан: Цахим борлуулалтаар хэдэн төгрөг хийсэн бэ?

З.Мөнхмаа: 240,0 сая ₮-ний борлуулалт хийсэн.

Ц.Зоригт: Цар тахлаас болж компанийн 50 жилийн ойн тэмдэглэх арга хэмжээ наадмаар амжихгүй болох нь. Бид уг нь төлөвлөгөө гаргаад тохижилтын ажил хийгээд л явж байна.

Л.Цэвээнравдан: Компанийн 50 жил маш чухал. Өөрийнхөө үндсэн үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулж байгаа компани ховор. Түүхэн замнал, бахархлаа гадаад, дотоодын харилцагчдад түгээх хэрэгтэй. Иймд энэ хурлын протоколоор, компанийн 50 жилийг тэмдэглэх төлөвлөгөө батлах, санхүүгийн эх үүсвэрийн талаар ТУЗ-д үүрэг болгоё.

Н.Батцэцэг: Үүнээс хойш ТУЗ-ийн хурлыг онлайнаар хийх шаардлага гарч байгаа. Иймд энэ талаар бэлтгэл ажлыг одооноос хийх хэрэгтэй байна.

З.Мөнхмаа: Zoom application-ийг суутгаад, том дэлгэц юмаа бэлтгээд, туршилт хийж үзэцгээе.

Ё.Энхтөр: Тооллогын комисс хэлэлцсэн асуудлуудад өгсөн саналыг танилцуул даа.

Г.Однаран: Тооллогын комиссын тогтоол №2-ыг танилцуулав. Санал хураалтын үр дүнгээр хэлэлцсэн 3 асуудалд хэрэлд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид 100 % зөвшөөрсөн санал өгсөн байна.

Ё.Энхтөр: Хурлын ажиллагаа өндөрлөж байна. Баярлалаа.

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Н.БАТЦЭЦЭГ

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧ:

Ё.ЭНХТӨР